

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ДАРГА

Д БАЯРБОЛД

Б.НАРАНТУЯА

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 05 сарын 14 өдөр

Дугаар ...х...

Улаанбаатар хот

Энэхүү "Ковид-19 болон аливаа цар тахын улмаас үүсэх хүндрэл, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулахын тулд эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүдийн чадаахыг бэхжүүлэх" ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний тухай хуулийн 343 дугаар зүйлийн 343.1-д заасныг үндэслэн,

Нэг талаас **НЭМГ**/цаашид "захиалагч" гэх/

Нөгөө талаас 9086331 регистрийн дугаартай **Эрүүл мэндийн хөгжлийн төв** /цаашид "гүйцэтгэгч" гэх/, түүнийг төлөөлж **төслийг хариуцагч Г.Хулан** нар /цаашид хамтад нь "талууд", тус тусад нь "тал" гэх/ дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гүйцэтгэгч нь ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООНЫ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ төсөл, хөтөлбөр, арга хэмжээг гэрээнд заасан хугацааны дотор хийж гүйцэтгэн, ажлын үр дүнг захиалагчид шилгүүлэх, захиалагч нь ажлын хөлсийг тодорхой хуваарийн дагуу олгох, ажлын гүйцэтгэлд хяналт тавихтай холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулна.

ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ТОХИРОЛЦСОН АЖИЛ

2.1. Гүйцэтгэх ажилд дараах ажил үүрэг багтана.

2.1.1 Сургалтын модул боловсруулах

2.1.2 Цахим сургалтууд

2.1.3. Видео хичээл бэлтгэх хөтөлбөр

2.2. Гүйцэтгэгч нь дээр заагдсан ажлыг гүйцэтгэх "Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө"-г батлан, хэрэгжүүлнэ.

2.3. Баталсан "Үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө" нь Гэрээний салшгүй хэсэг байна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, САНҮҮЖИЛТ

3.1. Гэрээний нийт үнийн дүн **21,840,000** / хорин нэгэн сая найман зуун дөчин мянга / төгрөг байна

3.2. Санхүүжүүлэгч нь: АХБ, ЯБЯС-ийн "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх" 9218-MON төсөл

3.3. Гэрээний төлбөрт ажлын гүйцэтгэлд холбогдох материалын болон бусад зардал, нэмэгдсэн өртгийн албан татаар зэрэг гарч болох бүхий л төлбөр, зардлууд багтсан болно.

3.4. Гэрээ хүчин төгөлдөр болж, гүйцэтгэлчийн нэхэмжлэлийг захиалагч хүлээн авснаас хойш төлбөрийн 70 хувийг, үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мөнгөн урьдчилгааны тайлан, санхүүгийн анхан шатны баримтын хамт хүлээн авч, актаар баталгаажуулсны дараа үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэлчийн **төрийн сан банкны 100900020405** дугаар дансанд тус тус шилжүүлнэ.

3.5. Захиалагч нь гүйцэтгэлчийн нэхэмжлэхийг хүлээн авсны дараа төлбөрийг гүйцэтгэлчийн дансанд шилжүүлнэ.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээ байгуулсны дараа гэрээний үнийг нэмэгдүүлэх эрхгүй.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1. Ажлын эхлэх хугацаа **2022 оны 05** дугаар сарын **10-ны өдөр**, үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа **2022 оны 06** дугаар сарын **10-ны өдөр** байх ба ажлын гүйцэтгэлийн үргэлжлэх хугацаа **1 сар** байна.

4.2. Гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

4.3. Талууд гэрээний хугацааг нарийн чанд мөрдөн ажиллана.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагчийн эрх, үүрэг:

5.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана.

5.1.2. Ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг шалгах бөгөөд "Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т зааснаас зөрүүтэй, стандартын шаардлага хангаагүй, чанаргүй хийсэн, дутуу хийсэн ажлыг гүйцэтгэх, дахин гүйцэтгэхийг шаардах, хүлээн авахаас татгалзах, шаардлагыг хүлээн аваагүй тохиолдолд гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж гарсан зардлыг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх, үлдэгдэл төлбөрөөс суутгана.

5.1.3. "Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т зааснаас зөрүүтэй, стандартын шаардлага хангаагүй, чанаргүй хийсэн, дутуу хийсэн ажлыг үнэ төлбөргүй буюу өөрийн зардлаар дахин/нөхөж гүйцэтгэх боломжгүй, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй ажлын төлбөрийг төлөхгүй байж болно.

5.1.4. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хоёр ба түүнээс дээш удаа биелүүлээгүй эсхүл гэрээнд заасан ажлын үр дүнг хүлээлгэн өгөх боломжгүй тохиолдолд гэрээг цуцлах санал гаргаж болно.

5.1.5. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авна.

5.1.6. Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүхий л мэдээ, мэдээлэл, зааварчилгааг өгнө.

5.1.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

5.2. Гүйцэтгэлийн эрх, үүрэг:

5.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардана.

5.2.2. Гүйцэтгэж байгаа ажилтай холбоотой нэмэлт мэдээлэл авна.

5.2.3. Гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан "Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

5.2.4. Ажил гүйцэтгэх явцад болон дараа илэрсэн зөрчил, чанарын доголдлыг тухай бүр өөрийн хөрөнгөөр арилгах, дахин эсхүл нөхөн гүйцэтгэнэ.

5.2.5. Гэрээний 4.1-д заасан хугацааг чанд баримтлана.

5.2.6. **2022** оны **06** дугаар сарын **10**-ны өдөрт багтаан үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мөнгөн урьдчилгааны тайланг санхүүгийн анхан шатны баримтын хамт ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газарт албан бичгээр хүргүүлэхээр ЭМЯ-ны бичиг хэрэгт хүлээлгэн өгнө.

5.2.7. Захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй.

5.2.8. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр зохион байгуулсан, бүтээсэн аливаа бүтээл, хөтөлбөр, арга хэмжээнд Эрүүл мэндийг дэмжих сангийн нэрийг дурьдана.

5.2.9. Захиалагчийн өгсөн шаардлага, заавар, зөвлөмжийг биелүүлнэ.

5.2.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Гүйцэтгэгч энэхүү гэрээний 4.1-д заасан хугацаанд "Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний ажлын даалгавар"-т заасан ажлыг эцэслэн дуусгаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар тооцож алданги төлнө.

6.2. Талуудын аль нэг нь гэрээгээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөнөөс болж нөгөө талдаа хохирол учруулбал учруулсан хохирлоо бүрэн хариуцна.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв дээрх аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1. Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээнд Талууд тохиролцон хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.3. Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Гүйцэтгэгч тал нэг хувийг, Захиалагч тал хоёр хувийг хадгалах бөгөөд эхүүд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ЕС. НУУЦЛАЛ

9.1. Талууд энэ гэрээний дагуу мэдэх болсон байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

9.2. Энэ заалт нь Гүйцэтгэгчийн бүх ажилтан, төлөөлөгч, туслан гүйцэтгэгчид нэг адил хамаарна.

АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1. Давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер гэх мэт байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр гэх мэт Талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

10.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Талууд харилцан тохиролцож, гэрээний үүргээ биелүүлэх хугацааг сунгах эсвэл тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл түр хойшуулж болно. Энэ тухай Гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна.

10.3. Энэхүү Гэрээний 10.1-д заасан нөхцөл байдал үүссэн, дууссан талаар Талууд нэг нэгэндээ нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдээгүйн улмаас нөгөө Талдаа учирсан хохирлыг буруутай Тал хариуцна.

10.4. Бараа материал, түүхий эдийн хомсдлын улмаас бий болсон үнийн өсөлт, үйлдвэрлэгч, бараа нийлүүлэгчийн шийдвэр, хязгаарлалт нь давагдашгүй хүчин зүйлд хамаарахгүй.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АХБ, 9218-МОН төслийн зохицуулагч

.....*Д.Жаргалсайхан*..... Д.Жаргалсайхан

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төслийг хариуцагч

.....*Б.Батцоож*..... Б.Батцоож

Хаяг: Засгийн газрын VIII байр,
Олимпын гудамж-2, Сүхбаатар дүүрэг
14210, Улаанбаатар хот
Утас: 51-263892

Хаяг: Энхтайвны гудамж – 13Б,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Утас:
Цахим шуудан: